



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 45 (330)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай*
- *"Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх техник туслалцааны зээлийн төсөл"-ийн хөгжлийн зээлийн гэрээг соёрхон батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2003 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2003 оны арванхоёрдугаар сарын 1 № 45 (330)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|--|-----|
| 577. | Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2003-11-13-ны хууль) | 969 |
| 578. | "Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх техник тусалцааны зээлийн төсөл"-ийн хөгжлийн зээлийн гэрээг соёрхон батлах тухай (2003-11-13-ны хууль) | 970 |
| 579. | Архивын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2003-11-13-ны хууль) | 970 |
| 580. | Шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2003-11-13-ны хууль) | 970 |
| 581. | Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай (2003-11-13-ны хууль) | 970 |
| 582. | Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай (2003-11-13-ны хууль) | 971 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 583. | Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 03 дугаар дүгнэлтийн тухай | Дугаар 47 | 971 |
|------|---|-----------|-----|

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|---|------------|-----|
| 584. | Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 177 | 971 |
|------|---|------------|-----|

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|------------|-----|
| 585. | Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Дугаар 222 | 972 |
|------|---|------------|-----|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Боловсролын тухай хуулийн

26.4 дэх хэсгийн "гэрээний үндсэн дээр" гэсний дараа "төлбөртэй", мөн хэсэгт "Төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно." гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2003 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР

2003 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр	МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ	Улаанбаатар хот
"ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТЕХНИК ТУСЛАЛЦААНЫ ЗЭЭЛИЙН ТӨСӨЛ"-ИЙН ХӨГЖЛИЙН ЗЭЭЛИЙН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ		
1 дүгээр зүйл. Монгол Улс, Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хооронд 2003 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр байгуулсан "Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх техник туслалцааны зээлийн төсөл"-ийн Хөгжлийн зээлийн гэрээг Монгол Улсын	Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.	
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР		
2003 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр	МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ	Улаанбаатар хот
АРХИВЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ		
1 дүгээр зүйл. Архивын тухай хуулийн 20 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 20.8 дахь хэсэг нэмсүгэй:	"23.1. Архивын баримтыг байгууллагын архивт тэдгээрийг зохион бүрдүүлсэн оны дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тооцож дор дурдсан хугацаагаар хадгалан уг хугацаа дууссаны дараа түүх, эрдэм шинжилгээний ач холбогдолтой хэсгийг нь төрийн архивт шилжүүлнэ."	
"20.8. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд холбогдох баримтын архивын ажлын зааврыг Улсын Ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, архивын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална."	3 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	
2 дугаар зүйл. Архивын тухай хуулийн 23.1-ийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР	
2003 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр	МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ	Улаанбаатар хот
ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ		
1 дүгээр зүйл. Шүүхийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 87 ¹ дүгээр зүйл нэмсүгэй:	аймаг, нийслэлийн шүүхэд түүний салбар архив ажиллана."	
"87 ¹ дүгээр зүйл. Иргэн, захиргааны хавтаст хэргийн архив	2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	
87 ¹ . 1. Улсын дээд шүүхэд иргэний болон захиргааны хавтаст хэргийн төрөлжсөн төв архив,	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР	
2003 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр	МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ	Улаанбаатар хот
ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ		
1 дүгээр зүйл. Прокурорын байгууллагын тухай хуулийн 52.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.	2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР		



2003 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45.7 дахь хэсгийн " төрөл, садангийн хүний" гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45.7 дахь хэсгийн " үр хүүхэд" гэснийг "үр хүүхдийнхээ" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

2003 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Улаанбаатар хот

Дугаар 47

Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 03 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 15.1.5-д заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45.7 дахь хэсгийн "Гэрч нь гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхэд, төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй" гэсэн заалтын "төрөл, садангийн хүний" гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "... өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, ..." гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 03 дугаар дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5.1.11-ийн " Гэр бүлийн гишүүн" гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрөл, садангийн хүнийг хэлнэ" гэсэн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "... өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, ..." гэсэн заалтыг зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 03 дугаар дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

Улаанбаатар хот

Дугаар 177

Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 17 дугаар зүйлийн 6 дугаар заалтыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 88 дугаар зарлигаар байгуулагдсан Эрдэмтэн,

мэргэжилтнүүдийн зөвлөлийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгчийн эдийн засгийн бодлогын зөвлөх Б. Намхайжанцан, Монгол Солонгосын хамтарсан "Сонжин" ХХК-ийн захирал Б. Намхайнямбуу нарыг нэмж оруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Б. БАГАБАНДИ

2003 оны 10 дугаар сарын 14-ний өдөр

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Улаанбаатар хот

Дугаар 222

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 16.1, 16.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтыг 1 дүгээр, "Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт даалгах нь:

2.1. бусад орнуудтай байгуулах холбогдох гэрээ, хэлэлцээрт тохирлын үнэлгээний үр дүнг хэрэглэх, харилцан хүлээн зөвшөөрөх талаар тусгаж, хэрэгжүүлэх арга хэмжээг 2004 онд багтаан зохион байгуулсугай;

2.2. экспортлогч орны холбогдох байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Монгол Улсад импортлох бараа, бүтээгдэхүүний тохирлыг тухайн орны нутаг дэвсгэрт баталгаажуулах асуудлыг судалж шийдвэрлэж байсугай;

2.3. стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний баримт бичгийг төвлөрүүлэн хадгалах улсын нэгдсэн сан, мэдээллийн сүлжээг бий болгох ажлыг холбогдох яам, агентлагуудтай хамтран хэрэгжүүлсүгэй;

2.4. бүтээгдэхүүний сорилтын лабораторийн техникийн түвшинг дээшлүүлэх, тохирлын үнэлгээний салбарт ажиллагсдын чадавхийг сайжруулах, техник хэрэгслээр хангах чиглэлээр төсөл боловсруулан олон улсын болон гадаад орны холбогдох байгууллагуудад санал болгож, ээлж дараатай шийдвэрлүүлж байсугай;

2.5. аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгчдийг чирэгдүүлэхгүй байх, сорилтын лабораториудын бие даасан, хараат бус байдлыг хангах, баталгаажуулалтыг "нэг цэг"-ийн үйлчилгээний зарчимд нийцүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчид байгаа лабораториудын тогтолцоог боловсронгуй болгох талаар холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран санал боловсруулж, 2004 оны I улиралд багтаан Засгийн газарт оруулж шийдвэрлүүлсүгэй.

3. Мөрдеж байгаа хүн, малын эмийн улсын стандартыг үндэслэн эмийн үндэсний фармакопей

бий болгох ажлыг зохион байгуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт даалгасугай.

4. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

4.1. энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг тохирлын баталгаанд бүрэн хамруулж, дүнг Стандартчилал, хэмжил зүйн төвд улирал бүр мэдээлж байх арга хэмжээ авсугай;

4.2. орон нутгийн стандартчилал, хэмжил зүйн төвийг мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлж, тэдгээрийг сургалтад хамруулж байсугай.

5. Стандартчилал, хэмжил зүйн төвийн дарга Ж.Хүрэлсүхэд даалгах нь:

5.1. худалдааг хөнгөвчлөх зорилгоор бүтээгдэхүүнийг импортлохоос өмнө тохирлын баталгаанд хамруулах чиглэлээр тохирлын үнэлгээний үр дүнг хэрэглэх, харилцан хүлээн зөвшөөрөх талаар худалдааны түнш орнуудын холбогдох байгууллагуудтай шаардлагатай гэрээ, хэлэлцээрийг зохих журмын дагуу байгуулах арга хэмжээ авсугай;

5.2. стандартын мэдээлэл, лавлагааны төвд хадгалагдаж байгаа хүн, малын эмийн түүхий эд, жор орц, тэдгээрийн шинжилгээний аргын стандартыг энэ онд багтаан холбогдох эмийн салбар зөвлөлд шилжүүлсүгэй;

5.3. мөрдеж байгаа үндэсний стандартуудын шинжлэх ухаан-техник, хууль зүйн түвшинд холбогдох яам, агентлаг, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран үзлэг явуулж, 2004 онд багтаан стандартын статусыг тодорхой болгосугай;

5.4. нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах объектод тогтоосон заавал мөрдеж үндэсний стандартын жагсаалтыг хэвлэн, нийтэд мэдээлж байсугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай"



Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 21-ний эдрийн 100 дугаар тогтоол, "Чанарын баталгаажуулалтыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2001 оны 3

дугаар сарын 13-ны эдрийн 45 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын
Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Үйлдвэр, худалдааны
сайд

Ч.ГАНЗОРИГ

Засгийн газрын 2003 оны 222 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ТОХИРЛЫН БАТАЛГААНД ЗААВАЛ ХАМРАГДАХ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Бүтээгдэхүүн:

Бүлэг №	Зүйл №	Мөр №	Үндэсний код	Барааны бичиглэл
02				Мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн
04	04.02	0403.10	00	Саахар болон бусад амтлагчийн хольцтой өтгөрүүлсэн сүү, цөцгий
	04.03			Йогурт
	04.05			Цөцгийн тос, сүүнээс гаргаж авсан бусад тос, өтгөн цөцгий
	04.06			Бяслаг ба аарц
	04.10			Бусад газар заагдаагүй мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн
05	05.04	0506.90	20	Мал, амьтны /загаснаас бусад/ шинэ, хөргөсөн, хөлдөөсөн, давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан, утсан бүтэн буюу хуваасан өлөн гэдэс
	05.06			Ясны гурил
09	09.01			Хуурсан буюу хуураагүй, кофеиноос цэвэрлэсэн кофе; кофены хальс, яс; тодорхой хэмжээний кофены агуулгатай кофег орлодог бүтээгдэхүүн.
	09.02			Амт, үнэр оруулсан буюу оруулаагүй /ферментжүүлсэн буюу ферментжүүлээгүй/ цай
11	11.01	1101.00		Улаан буудайн буюу улаан буудай-хөх тарианы гурил
	11.02	1101.00		Улаан буудайн буюу улаан буудай-хөх тарианы гурилаас бусад үр тарианы гурил
	11.04			Бусад аргаар боловсруулсан үр тарианы будаа (жишээ нь: цэвэрлэсэн, өнхөрүүлэгт оруулсан, хальсалсан, буталсан, жижиглэсэн (нунтагласан); үр тарианы үр хөврөл (нягтруулсан, хөвсийлгөсөн, нунтагласан).



15				Мал, амьтны болон ургамлын гаралтай тос, түүнийг задалж боловсруулсан бүтээгдэхүүн; идэшний тос; мал, амьтан, ургамлын гаралтай лав.
16	16.01			Мах, дайвар мах буюу цусан хиам, түүнтэй төстэй бүтээгдэхүүн; тэдгээрээр хийсэн хүнсний бэлдмэл
	16.02			Мах, дайвар мах болон цусаар хийсэн бусад бэлдмэл, тэдгээрийн лаазалсан бүтээгдэхүүн.
	16.04			Бэлдсэн буюу лаазалсан загас; загасны түрс буюу түүнийг орлох бүтээгдэхүүн.
17				Саахар, саахран бүтээгдэхүүн
18				Какао болон какаоны бэлдмэл
19				Үр тариа, гурил, цардуул, сүүн бэлдмэл; гурилан бүтээгдэхүүн
20				Хүнсний ногоо, жимс, самар буюу эд хэсгийн бэлдмэл
21				Төрөл бүрийн хүнсний бэлдмэл
22				Ус, ундаа, спирт, архи, дарс, цуу
24				Тамхи, түүнийг орлуулагч бүтээгдэхүүн
25	25.01	2501.00 2501.00 2501.00 2501.00	11 19 30	Хүнсний давс: Иоджуулсан Бусад Хүнсний биш давс
	25.23			Өнгө оруулсан буюу оруулаагүй, клинкер хэлбэрт оруулсан буюу оруулаагүй, портланд цемент, гуйлсаган цемент (хөнгөн цагаан цемент), шаарган цемент, суперсульфатын цемент ба тэдгээртэй төстэй усжсан бусад цемент
	25.29	2529.10	00	Хайлуур жонш
26	26.03			Зэсийн хүдэр ба баяжмал
	26.11			Гянт болдын хүдэр ба баяжмал
	26.12			Ураны буюу торийн хүдэр ба баяжмал
	26.13			Молибдений хүдэр ба баяжмал
27	27.01			Нүүрс; брикет, шахмал нүүрс болон нүүрснээс гаргаж авсан тэдгээртэй төстэй хатуу түлш. - Нунтагласан буюу нунтаглаасгүй, бөөмнөрүүлээгүй нүүрс:



	27.10	2710.00		Нефть ба битүүмжсэн эрдсээс гаргасан газрын тос /түүхий биш/; жингийн 70% буюу түүнээс их нефть буюу битумжсан эрдсээс гаргасан газрын тос агуулсан, бусад газарт тусгайлан заагдаагүй буюу ороогүй бэлдмэл /эдгээр газрын тос нь бэлдмэлийн үндсэн бүрэлдүүлэгч хэсэг нь байна/
28				Органик бус нэгдэл; үнэт ба газрын ховор металл, цацраг идэвхит элемент ба изотопын органик буюу органик бус нэгдэл
29				Органик химийн нэгдэл
30	30.02	3002.20	00	Хүн эмнэлгийн зориулалттай вакцин
		3002.30	00	Мал эмнэлгийн зориулалттай вакцин
	30.03			Жижиглэн худалдаалах тун хэлбэрт савлагдаагүй, урьдчилан сэргийлэх буюу эмчилгээний зориулалттай хоёр буюу түүнээс дээш найрлагатай эмийн бэлдмэл /Зүйл 30.02, 30.05, 30.06-д зааснаас бусад/
	30.04			Жижиглэн худалдаалах тун хэлбэрт савлагдаагүй, урьдчилан сэргийлэх буюу эмчилгээний зориулалттай холимог буюу холимог бус эм /Зүйл 30.02, 30.05, 30.06-д зааснаас бусад/
31				Бордоо
32	32.02			Нийлэг, органик идээлэгч бодис, органик бус идээлэгч бодис байгалийн гаралтай идээлэгчийг агуулсан буюу агуулаагүй идээлэгч бэлдмэл, идээлэхийн өмнөх боловсруулалтын ферментийн бэлдмэл
	32.04			Химийн хувьд тодорхойлогдсон буюу тодорхойлогдоогүй нийлэг органик өнгө оруулагч бодис энэ бүлгийн 3 дугаар тайлбарт заасан нийлэг органик өнгө оруулагч бодист суурилсан бэлдмэл; флуоресцент тодотгогч болгон эсвэл люмонофор болгон ашигладаг, химийн хувьд тодорхойлогдсон буюу тодорхойлогдоогүй нийлэг органик бүтээгдэхүүн
	32.08			Нийлэг буюу байгалийн хувиргасан полимерт суурилсан, усан биш орчинд уусгасан буюу булингажуулсан найруулсан будаг, чий (лак) (пааландах будаг буюу маажин орно); энэ бүлгийн 4-р зүйлд заасан үүсмэл
	32.09			Нийлэг буюу байгалийн хувиргасан полимерт суурилсан, усан орчинд уусгасан буюу булингажуулсан найруулсан будаг, чий (лак) пааландах будаг буюу маажиндах чий орно.
33	33.03	3303.00	00	Үнэртэй ус, ариун цэврийн ус

	33.04			Гоо сайхны бэлдмэл, биений арьс арчилж, хамгаалах бэлдмэл (эмийн бэлдмэлээс бусад наранд шарах ба нарнаас хамгаалах бэлдмэл орно); хумс заслын бэлдмэл.
	33.05			Үс арчлах бэлдмэл
	33.06			Амны хөндий, шүдний ариун цэврийн бэлдмэл, хиймэл шүд бэхжүүлэх нунтаг, шахмал оо; жижиглэн худалдаалах нэг бүрийн боодолтой шүдний мяндсан чигчлүүр.
34	34.01	3401.11	00	Гар нүүрийн саван (эмийн бэлдмэлтэй бүтээгдэхүүн орно)
		3401.19	10	Эдийн саван
	34.02	3402.20	10	Жижиглэн худалдах зориулалтаар савласан бэлдмэл; угаалгын нунтаг
	34.02			Гадаргуугийн идэвхит органик бодис (савангаас бусад); гадаргуугийн идэвхит бэлдмэл (туслах чанарын угаалгын бэлдмэл орно) ба Зүйл №34.01-д заагдсанаас бусад саван агуулсан буюу агуулаагүй цэвэрлэгээний бэлдмэл
	34.03	3403.11	00	Нэхмэл материал, арьс шир, үслэг эдлэл буюу бусад материалыг боловсруулахад зориулагдсан бэлдмэл
	34.04	3404.20	00	Полиэтилен гликолийн лав
35	35.07			Фермент; бусад газар заагдаагүй ферментийн бэлдмэл
36				Тэсрэмтгийн бодис
	36.01	3601.00	00	Дарь, тийрэлтэт түлш
	36.02	3602.00	00	Дарь, тийрэлтэт түлшнээс бусад тэсрэгч бэлдмэл
	36.03	3603.00	00	Гал дамжуулах аюулгүй утас; тэсэлгээний утас; цохилтын буюу тэсэлгээний бялтат бүрхүүл; ноцоогуур; цахилгаан тэслүүр
	36.04			Гэрэлтэн шатагч зүйлс, дохионы гэрэлт пуужин, аадар эсэргүүцэх, манантай үеийн дохиоллын пуужин, пиротехникийн бусад хэрэгсэл
38	38.05	3805.10	00	Мод ба сульфатын шингэрүүлсэн давирхай
	38.08	3808.20	00	Фунгицид

	38.09	3809.10	00	Цардууллаг бодис дээр суурилагдсан бэлдмэл
		3809.91	00	Нэхмэл буюу түүнтэй төстэй үйлдвэрлэлийн зориулалттай бэлдмэл
		3809.92	00	Цаас буюу түүнтэй төстэй үйлдвэрлэлийн зориулалттай бэлдмэл
		3809.93	00	Арьс шир буюу түүнтэй төстэй үйлдвэрлэлийн зориулалттай бэлдмэл
41	41.04			Зүйл №41.08 буюу 41.09-д зааснаас бусад үсийг нь унагасан адуу, үхрийн шир
	41.05			Зүйл №41.08 буюу 41.09-д зааснаас бусад хонь, хурганы үсгүй арьсаар хийсэн савхи буюу шеврет
	41.06			Зүйл №41.08 буюу 41.09-д зааснаас бусад ямаа, ишигний үсгүй арьсаар хийсэн савхи буюу шеврет
44	44.01	4401.10	00	Түлшний мод (гуалин, хэрчим мод, мечир, гишүү буюу тэдгээртэй төстэй хэлбэрийн)
	44.03			Холтослосон буюу холтослоогүй эсвэл дөрвөлжилж зассан мод
	44.06			Төмөр замын буюу трамвайны замын дэр мод
	44.07			Зузаан нь 6 мм-ээс их, хөрөөдсөн, уртын дагуу зүссэн, хэрчсэн (харуулдсан буюу харуулдаагүй, зүлгэсэн буюу зүлгээгүй, углуурган холбоостой буюу холбоосгүй мод)
	44.09			Залгаасгүй тодорхой хэлбэр (ховилтой, углуургатай, хашлагатай өнцгийг нь дарсан, хагас дугуй, дугуй гэх мэт) бүхий харуулдсан буюу харуулдаагүй, зүлгэсэн буюу зүлгээгүй, углуурган холбоостой буюу холбоосгүй мод (зүймэл модон шалны зориулалтын харуулдсан, нийлүүлээгүй мод ба хөндлөвч орно)
	44.12			Фанер, хуулга наасан хавтан ба давхарлаж наасан адил төстэй модон материал
	44.13			Дөрвөлжин, хавтгай, тууз хэлбэрийн буюу хэлбэржүүлэн нягтруулсан мод
	44.18			Барилгын дархны модон эдлэл, хөндий, хавтан, зүймэл модон шал /нийлүүлсэн/, хавтан, дээврийн ба бусад савх мод



48	48.03	4803.00	00	Гэр ахуй, ариун цэврийн зориулалттай гар нүүр, жорлонгийн цаас, цаасан алчуур, амны цаасан алчуур буюу тэдгээртэй төстэй цаас, гадаргууд нь хэв, атираа, нугалаас үүсгэсэн, нүхэлсэн, будсан, хээлж чимэглэсэн буюу ийм боловсруулалт хийгээгүй, хуудаслан зүссэн буюу хуйлмал хэлбэрийн, целлюлозон хөвөн ба целлюлозон зулмал
51	51.05			Сэмлэсэн буюу самнасан хонины ноос буюу мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгас
57				Хивс ба бусад нэхмэл дэвсгэр
61	61.01		10	Хонины ноосон сүлжмэл хувцас ба сүлжмэл тоног хэрэгсэл
	61.17		20	Ямааны ноолууран сүлжмэл хувцас ба сүлжмэл тоног хэрэгсэл
			30	Тэмээний ноосон сүлжмэл хувцас ба сүлжмэл тоног хэрэгсэл
62	62.07			Эрэгтэйчүүдийн буюу хөвгүүдийн майк, агтавч, дотуур өмд, унтлагын цамц, унтлагын өмд цамцны хослол, усны, гэрийн халат ба ижил төстэй зүйлс;
	62.08			Эмэгтэйчүүдийн буюу охидын майк, сарафан, дотуур банзал, агтавч, дотуур өмд, унтлагын даашинз, унтлагын өмд цамцны хослол, гэрийн нимгэн халат, усны, гэрийн халат ба ижил төстэй зүйлс;
	62.12			Оёмол буюу сүлжмэл, хөхний даруулга, бүс, гэдэсний даруулга, мөрөвч, өмдний татуурга, оймсны татуурга болон тэдгээртэй ижил төстэй эдлэл ба тэдгээрийн эд анги.
63	63.02			Орны цагаан хэрэглэл, ширээ, ариун цэвэр ба гал тогооны даавуун хэрэглэл.
68	68.06	6806.10		Гулдмай, хуудас буюу хуйлмал байдалтай шаарган хөвөн, эрдэс чулуун хөвөн ба тэдгээртэй төстэй эрдэс хөвөн (тэдгээрийн холимог орно).
		6806.10	10	Эрдэс хөвөн
	68.07			Асфальт буюу түүнтэй төстэй материал (нефтийн битум, чулуун нүүрсний давирхай)-аар хийсэн бүтээгдэхүүн
		6807.10	10	Хар цаас



	68.08			Цемент, гөлтгөнө, бусад эрдэс материалын холбогчтой ургамлын мяндас, сүрэл, модны үртэс, зоргодос, зах зэрэг материалаар хийсэн хавтан, хавтанцар, гулдмай ба адил төстэй материал.
	68.10			Цемент, бетон болон хиймэл чулуун, хүчитгэсэн буюу хүчитгээгүй бүтээгдэхүүн.
72	72.06			Цутгамал болон анхдагч бусад хэлбэртэй төмөр ба чанаржуулаагүй ган
	72.13			Халуунаар цувисан, зөв бус хэлбэрийн ороомог байдалтай, төмөр буюу чанаржуулаагүй гангаар хийсэн цулдан ба туйван
	72.14			Давтах, халуунаар цувих, халуунаар сунгах болон даралтаар шахаж, цувихаас цаашид боловсруулалт хийгээгүй, цувисны дараа мушгисан, төмөр буюу чанаржуулаагүй гангаар хийсэн бусад цулдан ба туйван
	72.15			Төмөр буюу чанаржуулсан гангаар хийсэн бусад цулдан ба туйван
	72.16			Төмөр буюу чанаржуулаагүй гангаар хийсэн булан, хэлбэрт болон сортын төмөр
73	73.03	7303.00	00	Ширмэн, нарийн, бүдүүн хоолой ба хөндий огтолбор
	73.04			Төмөр (ширэмнээс бусад) буюу гангаар хийсэн, ширээсгүй, нарийн бүдүүн хоолой ба хөндий огтолбор
	73.08			Төмөр хийц, түүний эд анги, төмөр буюу гангаар хийсэн төмөр хийц үйлдвэрлэх зориулалттай хавтан, туйван, булан хэлбэрт болон сортын төмөр, хоолой ба тэдгээртэй төстэй зүйлс
74				Зэс ба түүгээр хийсэн эдлэл
85	85.09			Өөртөө цахилгаан хөдөлгүүр бүхий гэр ахуйн зориулалтын цахилгаан-механик хэрэгсэл
	85.10			Өөртөө цахилгаан хөдөлгүүр бүхий үс засах, үс хяргах, сахал хусах хэрэгсэл
	85.16	8516.10		Ус хурдан буцалгагч буюу ус хадгалагчийг халаагч, дүрдэг халаагч,
		8516.31		Үс хатаагч
		8516.33		Гар хатаагч
		8516.40		Цахилгаан индүү
		8516.50		Бичил долгионы зуух
		8516.60		Бусад зуух, плитка, чанагч ширэм, буцалгагч тогоо, шарагч шүүгээ, жигнэгч шүүгээ
				Цахилгаан халаагуурт бусад хэрэгсэл:
		8516.71		Кофе, цай чанагч

		8516.72		Талх шарагч
	85.20			Дуу сэргээгчтэй буюу сэргээгчгүй магнитофон болон дуу авиа бичлэгийн бусад төхөөрөмж
	85.21			Дүрс бичигч болон сэргээгч төхөөрөмж
	85.28			Радио нэвтрүүлэг хүлээн авагч, дуу, дүрс бичлэгийн болон сэргээгч аппарат хэрэгсэлтэй буюу хэрэгсэлгүй, телевизийн нэвтрүүлэг хүлээн авах аппарат, видео монитор ба видео проектор
95	95.01			Хүүхэд унаж тоглох дугуйт тоглоом /жишээ нь: унадаг гурван дугуйт, өөрөө явагч, гишүүрт машин/; хүүхэлдэйн тэрэг
	95.02			Зөвхөн хүн дүрстэй хүүхэлдэй.
	95.03			Бусад тоглоом; овор хэмжээ (масштаб)-г нь багасгасан загвар буюу түүнтэй төстэй, зугаа цэнгээний хөдөлгөөнт буюу хөдөлгөөнт биш загвар; бүх төрлийн оньсон тоглоом.

Үйлчилгээ:

1	Үсчин
2	Гоо сайхан
3	Халуун ус
4	Сауна
5	Хими цэвэрлэгээ
6	Авто засварын газар
7	Шатахуун түгээх станц
8	Хүүхдийн тоглоомын газар
9	Нийтийн тээвэр
10	Зочид буудал, жуулчны бааз
11	Мод, модон материалын зах
12	Нийтийн хоолны газар
13	Дэлгүүр, бөөний худалдааны төв

Засгийн газрын 2003 оны 222 дугаар
тогтоолын 2 дугаар хэсэрлэлт

ТОХИРЛЫН БАТАЛГААТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗАХ ЗЭЭЛД НИЙЛҮҮЛЭХ, ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Эрүүл мэнд, Хүнсний тухай хуулиуд, Дэлхийн худалдааны байгууллагын "Худалдаан дахь саад тотгорын тухай хэлэлцээр", тохирлын баталгааны үр дүнг хэрэглэх, харилцан хүлээн зөвшөөрөх талаар гадаад орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд хүрээлэн буй орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулахгүй байх зорилгоор бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тохирлын баталгаанд заавал хамруулах, тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ, гадаад, дотоод худалдааны үйл ажиллагааг эрхэлж байгаа өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг /цаашид "бүтээгдэхүүн" гэх/ Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Стандартчилал, хэмжил зүйн төвөөс итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллага /цаашид "баталгаажуулалтын байгууллага" гэнэ/ бүтээгдэхүүнд тохирлын баталгаажуулалт хийнэ.

1.4. Бүтээгдэхүүнд тохирлын баталгаа гаргахад Стандартчиллын үндэсний зөвлөлөөс баталсан стандарт, арга зүйн удирдамжийг ашиглана.

1.5. Энэхүү журамд хэрэглэсэн тохирлын үнэлгээ, гэрчилгээ, тэмдэг болон тохирлын баталгаатай холбогдолтой бусад нэр томъёог Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, Олон улсын стандартчиллын байгууллага /ISO/, Олон улсын цахилгаан техникийн комисс /IEC/-ын арга зүйн удирдамжид заасны дагуу ойлгоно.

1.6. Энэхүү журмын дагуу олгох тохирлын гэрчилгээ, өргөдлийн маягт, шинжээчийн дээж авсан протокол, нийлүүлэгчийн мэдэгдэл, баталгаажуулалтын байгууллагын мэдэгдлийн загварыг Стандартчиллын үндэсний Зөвлөлөөс батална.

1.7. Гадаад орнуудтай тохирлын баталгаатайгаар харилцан нийлүүлэхээр тохиролцсон барааны жагсаалт, итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын нэр, тохирлын тэмдгийн загвар, нийлүүлэгчийн мэдэгдэл, тэдгээрт гарсан өөрчлөлтийн тухай мэдээллийг Улсын гаалийн ерөнхий газар болон Улсын мэргэжлийн хяналтын байгууллагад тухай бүр өгч байна.

1.8. Стандартчилал, хэмжил зүйн төвөөс шаардлагатай гэж үзсэн гаальд энэхүү журмыг хэрэгжүүлэх зорилгоор баталгаажуулалтын шинжээчийг томилон ажиллуулна.

1.9. Монгол Улсын Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд энэхүү журам хамаарахгүй.

Хоёр. Тохирлын баталгаа гаргах

2.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь /цаашид "хүсэлт гаргагч" гэнэ/ заавал тохирлын баталгаанд хамрагдах бүтээгдэхүүний жагсаалтад /цаашид "жагсаалт" гэнэ/ орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл эхэлснээс хойш гурван сарын дотор чанар, аюулгүй байдлын тохирлын баталгаажуулалтад хамруулна. Хүсэлт гаргагч нь дараахь материалыг батлагдсан маягтын дагуу бүрдүүлэн баталгаажуулалтын байгууллагад ирүүлнэ:

2.1.1. бүтээгдэхүүнээ баталгаажуулалтад хамруулах тухай өргөдөл;

2.1.2. үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, бүтээгдэхүүний чанар, тохирлын тогтвортой байдлыг хангах талаар хийж байгаа ажлын талаархи танилцуулга.

2.2. Баталгаажуулалтын байгууллага хүсэлт гаргагчаас ирүүлсэн материалыг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан танилцаж, тохирлын үнэлгээ явуулах хугацааг тохирно.

2.3. Ирүүлсэн материал шаардлага хангаагүй тохиолдолд энэ тухай хүсэлт гаргагчид албан бичгээр хариу мэдэгдэнэ.

2.4. Баталгаажуулалтын байгууллага бүтээгдэхүүнд үнэлгээ явуулахдаа тухайн салбарын мэргэшсэн шинжээчээс бүрдсэн ажлын хэсэг /цаашид "шинжээч" гэнэ/ томилж ажиллуулна.

2.5. Жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг баталгаажуулалтад бүрэн хамруулах зорилгоор энэ журмын 2.1-д заасан хугацаанд бүтээгдэхүүнээ баталгаажуулалтад хамруулаагүй аж ахуйн нэгж, байгууллагад баталгаажуулалтын байгууллага мэдэгдэл өгч болно.

2.6. Шинжээч дараахь ажлыг хийж гүйцэтгэнэ:

2.6.1. холбогдох стандарт, аргазүйн удирдамжийн дагуу хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн сорилт шинжилгээний дүнг ашиглан тухайн бүтээгдэхүүн нь техникийн зохицуулалт, стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох;

2.6.2. бүтээгдэхүүний стандартаар тогтоосон үзүүлэлт тус бүрээр үйлдвэрлэлийн технологийн тогтвортой байдалд дүгнэлт гаргах;

2.6.3. чанарын дотоод хяналт, чанарын удирдлагын тогтолцоо болон түүний баталгаажуулалт, бүтээгдэхүүний чанарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаатай танилцаж дүгнэлт гаргах;

2.6.4. холбогдох стандарт, баталгаажуулалтын схемийн дагуу үйлдвэрлэлийн шугам, худалдааны цэгээс авсан бүтээгдэхүүний дээжийг итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораториор шинжлүүлэн техникийн зохицуулалт, стандарт, норматив баримт бичигт заасан үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг тогтоох;

2.6.5. сорилт, шинжилгээнд хамруулах боломжгүй бүтээгдэхүүний тохирлыг үнэлэхдээ хүсэлт гаргагчаас хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн дунд явуулсан санал асуулгын дүнг үндэслэл болгох;

2.6.6. үйлдвэрлэл, үйлчилгээний орчин, эрүүл ахуй, байгаль орчин, аюулгүй ажиллагааны үзүүлэлтүүдийг холбогдох стандарт, норматив техникийн баримт бичгийн дагуу үнэлэх, шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах;

2.6.7. үнэлгээний үр дүнгийн талаар хүсэлт гаргагчид урьдчилан танилцуулах;

2.6.8. үнэлгээ явуулсан дүнгийн тухай тайланд дараахь асуудлыг тодорхой тусгах:

2.6.8.1. үнэлгээний дүнгээр бүтээгдэхүүн нь стандарт, норматив техникийн баримт бичгийн шаардлагад тохирч байгаа тохиолдолд асуудлыг баталгаажуулалтын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх тухай санал;

2.6.8.2. бүтээгдэхүүн нь стандарт, норматив техникийн баримт бичгийн шаардлагад тохирохгүй байгаа бол давтан үнэлгээ явуулах хугацааг хүсэлт гаргагчтай тохирох;

Анхдагч болон давтан үнэлгээ хоорондын хугацаа нэг сараас багагүй байна.

2.6.9. давтан үнэлгээнд зөвхөн тухайн шаардлага хангаагүй асуудлыг хамруулах.

2.7. бүтээгдэхүүний тохирлын тогтвортой байдлыг тодорхойлоход техникийн хяналтын байгууллагын дүгнэлтийг ашиглаж болно.

2.8. Шинжээч нь жагсаалтад орсон бүтээгдэхүүнд баталгаажуулалт явуулахдаа аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, мэдээ баримтыг авч танилцах, шаардлагатай багаж, төхөөрөмж хэрэглэх, илэрсэн зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх бүрэн эрхтэй байна.

2.9. Баталгаажуулалтын шинжээч нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

2.10. Бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалтад итгэмжлэгдсэн сорилтын лаборатори дараахь үүргийг хэрэгжүүлнэ:

2.10.1. итгэмжлэлээр тогтоосон хүрээнд тухайн бүтээгдэхүүний үзүүлэлтүүдийг шинжээчийн дээж авсан протоколд дурдсан техникийн зохицуулалт, стандарт, норматив-техникийн баримт бичгийн дагуу тодорхойлох;

2.10.2. гүйцэтгэсэн сорилтын үр дүнгийн үнэн зөвийг хариуцах;

2.10.3. сорилтын дүнг шинжээчид өгөхдөө батлагдсан сорилтын дүнгийн хуудсанд лабораторийн тэмдэг дарж, эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байх;

2.10.4. лабораторийн шинжилгээнд ирүүлсэн дээж шаардлага хангаагүй тохиолдолд үндэслэлийг гарган буцаах.

2.11. Лабораторийн сорилт шинжилгээ явуулах, шинжээчийн дүгнэлт гаргахад дараахь норматив баримт бичгийг ашиглана:

2.11.1. үндэсний стандарт;

2.11.2. техникийн зохицуулалт;

2.11.3. олон улсын болон бүс нутгийн стандарт, бусад норматив баримт бичиг;

2.11.4. худалдан авагчтай худалдааны гэрээгээр тохирсон стандарт болон бусад норматив баримт бичиг.

2.12. Баталгаажуулалтын төрөл бүрээр батлагдсан стандартын дагуу үнэлгээ явуулсан шинжээчийн дүгнэлтийг үндэслэн баталгаажуулалтын байгууллагаас тохирлын гэрчилгээ олгоно.

2.13. Бүтээгдэхүүнд үндэсний тохирлын тэмдэг хэрэглэх тухай шийдвэрийг баталгаажуулалтын байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын төв байгууллага гаргана.

2.14. Хүсэлт гаргагч нь баталгаажуулалтын байгууллагатай Үндэсний тохирлын тэмдэг, тохирлын гэрчилгээ хэрэглэх тухай гэрээг 3 жил хүртэлх хугацаагаар байгуулна.

2.15. Гэрээнд дараахь асуудлыг тусгасан байвал зохино:

2.15.1. үнэлгээний явцад олж авсан мэдээллийн нууцлал;

2.15.2. тохирлын гэрчилгээ болон тохирлын тэмдгийг зар сурталчилгаанд ашиглах, тэдгээрийг урвуулан ашиглах, хэрэглэгчийг төөрөгдүүлэх зэрэг үйлдэлд авах арга хэмжээ, хүлээх хариуцлага;

2.15.3. тохирлын тэмдэгтэй бүтээгдэхүүний чанарын тогтвортой байдлыг шалгах хугацаа;

2.15.4. тохирлын тэмдэг хэрэглэх хугацааг сунгах, түдгэлзүүлэх, зогсоох нөхцөл, шаардлага;

2.15.5. тохирлын тэмдэгтэй бүтээгдэхүүний стандартад өөрчлөлт орсон үед авах арга хэмжээ;

2.15.6. баталгаажуулалттай холбогдуулан гаргасан хүсэлт, маргааныг шийдвэрлэх.

2.16. Үндэсний тохирлын тэмдэг, тохирлын гэрчилгээ хэрэглэж байгаа бүтээгдэхүүн, үйлдвэрлэгч/нийлүүлэгчийн бүртгэлийг холбогдох баталгаажуулалтын байгууллага хөтөлж, нэгдсэн дүнг Стандартчилал, хэмжил зүйн төвд тогтоосон хугацаанд мэдээлж байна.

2.17. Баталгаажуулалтын байгууллага нь үндэсний тохирлын тэмдэг, тохирлын гэрчилгээ хэрэглэж байгаа бүтээгдэхүүний тохирлын тогтвортой байдлыг гэрээнд заасан хугацаанд шалгана.

2.18. Тохирлын тогтвортой байдлын шалгалтад итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн болон итгэмжлэгдсэн техникийн хяналтын байгууллагын дүгнэлтийг ашиглана.

2.19. Үйлдвэрлэгч/нийлүүлэгч бүтээгдэхүүндээ Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан нийлүүлэгчийн мэдэгдэл гаргаж болно.

2.20. Сорилтын үр дүн, бүтээгдэхүүн болон удирдлагын тогтолцооны гэрчилгээ, хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, амьтан, ургамал, байгаль орчинд сөрөг нөлөөгүйг нотолсон дүгнэлтийг үндэслэн нийлүүлэгчийн мэдэгдлийг гаргана.

2.21. Хүсэлт гаргагч нийлүүлэгчийн мэдэгдлийг холбогдох үндэсний стандарт, аргазүйн удирдамжийн дагуу гаргаж, Стандартчилал, хэмжил зүйн төвд бүртгүүлнэ.

Гурав. Бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, хилээр нэвтрүүлэх

3.1. Бүтээгдэхүүн экспортлогч, импортлогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь жагсаалтад орсон бүтээгдэхүүнээ тохирлын баталгаанд хамруулсны дараа зах зээлд нийлүүлэх буюу хилээр нэвтрүүлнэ.

3.2. Экспортлогч, импортлогч нь үйлдвэрлэгч өөрөө биш байх тохиолдолд дараахь материал болон бүтээгдэхүүний сорилтын үр дүнг үндэслэн хилээр нэвтрүүлэх бүтээгдэхүүний



зөвхөн тухайн хэсэгт баталгаажуулалтын байгууллага тохирлын гэрчилгээ олгоно:

3.2.1. бүтээгдэхүүнээ баталгаажуулалтад хамруулах тухай өргөдөл;

3.2.2. худалдан авагчтай байгуулсан гэрээний хуулбар (албан ёсны).

3.3. Энэ журмын 3.2.1, 3.2.2-т заасан материалыг бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэхээс өмнө ажлын 10 хоногт багтаан баталгаажуулалтын байгууллагад өгсөн байна.

3.4. Тохирлын гэрчилгээнд барааны кодыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)"-ийн зүйлийн түвшинд эхний 4 орноор бичнэ.

3.5. Жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн байгууллага дараахь эрхтэй байна:

3.5.1. чанар, хэрэглээний аюулгүй байдал, тохирлын баталгааны баримт бичгийн үзүүлэлт, шаардлага болон үндэсний тохирлын тэмдэг, тохирлын гэрчилгээний зөрчилгүй бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрөх;

3.5.2. үндэсний тохирлын тэмдэг, тохирлын гэрчилгээ, тухайн бүтээгдэхүүнийг экспортлогч орны эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаас олгосон хүчин төгөлдөр тохирлын гэрчилгээ, эсхүл олон улсын стандартчиллын байгууллагаас гаргасан стандарт, зөвлөмжийн дагуу гаргасан нийлүүлэгчийн мэдэгдэл болон түүнтэй адилтгах хүчин төгөлдөр баримт, бичиггүйгээр улсын хилээр нэвтрүүлэхгүй байх;

3.5.3. энэ журмын 3.5.2-т заасан шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг гаалийн баталгаат агуулахад саатуулж, энэ журмын 1.3-д заасан байгууллагаар тохирлын баталгаажуулалт хийлгэх.

3.6. Энэ журмын 3.5.2-т заасан баримт бичиг бүрдүүлэх боломжгүй импортлогч нь

бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэхийн өмнө баталгаажуулалтын байгууллагад хүсэлт гарган энэ журмын 2.1, 3.2-ын дагуу тухайн бүтээгдэхүүний загварыг баталгаажуулалтад хамруулж, үндэсний тохирлын тэмдэг, тохирлын гэрчилгээ авч болно.

3.7. Жагсаалтад зааснаас бусад бүтээгдэхүүнийг заавал тохирлын баталгаатайгаар харилцан нийлүүлэхээр худалдааны гэрээ, хэлэлцээрт тусгасан бол энэ журмын 3.5-ыг баримтална.

3.8. Дараахь нөхцөл хангасан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт, сорилт шинжилгээ давтан хийхээс чөлөөлнө:

3.8.1. үндэсний тохирлын тэмдэгтэй бүтээгдэхүүн;

3.8.2. бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалтын үр дүнг хэрэглэх, харилцан хүлээн зөвшөөрөх талаар олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ хэлэлцээрээр тохирсон хүчин төгөлдөр тохирлын тэмдэг, тохирлын гэрчилгээтэй экспортын болон импортын бүтээгдэхүүн;

3.8.3. чанарын (ИСО 9000) болон байгаль орчны удирдлагын тогтолцоо (ИСО 14000), аюул шинжлэх эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо (НАССР) нэвтрүүлж гэрчилгээ авсан аж ахуйн нэгжийн тухайн гэрчилгээнд дурдсан салбар, чиглэлд хамаарч байгаа тохирлын тэмдэгтэй бүтээгдэхүүн;

3.8.4. эко тэмдэгтэй бүтээгдэхүүн.

Дөрөв. Бусад

4.1. Бүтээгдэхүүний тохирлын баталгааны талаар баталгаажуулалтын байгууллага болон хүсэлт гаргагчийн гаргасан зөрчилд Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 2